



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 21 өдөр

Дугаар 278

Улаанбаатар хот

Сургалтын зардал гаргах
тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 заалтууд, яамны 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, спортын салбарын бүртгэл санхүүгийн ажилтнуудын мэргэжил, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Шилэн дансны хууль болон санхүү, бүртгэлийн холбогдолтой шинэчлэгдсэн хууль эрх зүйн заалтууд, түүний хэрэгжилтийг сайжруулах, харилцан туршлага солилцох чиглэлээр аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар, харьяа байгууллагуудын эдийн засагчдын мэргэжил дээшлүүлэх сургалтыг 2015 оны 07 дугаар сарын 27-ноос 08 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга /Ч.Бат-Эрдэнэ/ нарт даалгасугай.

2. Эрүүл мэнд, спортын салбарын бүртгэл санхүүгийн ажилтнуудын мэргэжил, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдах эдийн засагчдыг сургалтад бүрэн хамруулахыг орон нутгийн болон харьяа байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Сургалтад шаардагдах зардлыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2015 онд батлагдсан төрийн албан хаагчдын мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх зардлаас гаргахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга /Ч.Бат-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080969